

ХАДНЫ ОРШУУЛГА ХИЙГЭЭД ЭРТНИЙ НҮҮДЭЛЧИД ИХЭС ДЭЭДСЭЭ НУУЦ ДАЛДАД ОРШООДОГ ТУХАЙ

С.ХҮРЭЛСҮХ

ШУА-ийн Археологийн хүрээлэн
e-mail: khurelsukh_s88@yahoo.com

Түлхүүр үгс: Монголын археологи, дундад зууны үе, нүүдэлчдийн булш оршуулга, хадны оршуулга, агуйн оршуулга

ТОВЧ АГУУЛГА: Энэхүү өгүүлэлд зохиогч археологийн хэрэглэгдхүүн болон түүхийн сурвалжсийн мэдээн дээр тулгуурлан хадны оршуулгыг өвөрмөц гэхээс илүү нууц далд оршуулгын нэгэн хэлбэр (хувилбар) байж болох тухай авч үзжээ. Түүхийн янз бүрийн үед тухайн нийгмийн ноёлох хэсгийн төлөөлөл талийгаачийг хөрс зүйх, мөр дайруулах, ингэ буйлуулах, гэрчийн хэл таслах, хориг тогтоох, манаа гаргах, мод тарих, үл тэмдэглэх, мөрөө баллаж төөрөгдүүлэх зэргээр далд нууц оршуулж байснаас гадна агуй хаданд нууж оршоох заншил байсан гэж үзэж байна. Сүүлийн жилүүдэд олдон малтан судалсан хадны оршуулгуудын ихэнхийг их бага хэмжээгээр тонож сүйтгэсэн хэдий ч харьцангуй бага сүйдсэн Алхамын хавцалын оршуулгын торго, мөнгөн ээмэг, Цагаан Ханангийн оршуулгын язгуур сурвалжит хүний малгай, гутал, хувцас өмсгөл, Нартын Хадны оршуулгын эмэгтэйн хувцас, чимэглэлийн байдал нь Юан гүрний үеийн зургадугаар дэсээс доошгүй язгуур сурвалжтай хүний эд хэрэглэлтэй үндсэндээ тохирч байдаг бол Дугуй Цахирын оршуулга язгуур угсаатай баян чинээлэг хүний, Арцат Дэл, Жаргалант Хайрхан, Ёдортын оршуулга жирийн иргэдийнх бус болохыг оршуулгын эд хэрэглэгдэхүүн нотлон харуулдаг. Тиймээс бид биет хэрэглэгдэхүүнд дулдуйдан хадны оршуулга нь жирийн иргэдийнх байхаас илүүтэй язгууртан буюу тухайн нийгмийн ноёлох чинээлэг хэсгийнхний оршуулга байх бүрэн боломжтой хэмээн урьдчилсан байдлаар үзэж байна.

Монгол нутагт орших эртний булш оршуулгын дурсгал, археологийн болон сурвалж бичгийн хэрэглэгдэхүүнээс эрт цагийн нүүдэлчид талийгаачийг нутаглуулахдаа газар ухаж булшлах, хөрсөн дээр тавьж чулуугаар дараас үйлдэх, бунхлах, чандарлах, занданшуулах, хаданд тавих, элсэнд суулгах, язгуур сурвалжит хүнээ нууж далд оршоох зэрэг олон хэлбэрийн оршуулгын зан үйлтэй байгааг мэдэж болно.

Эл өгүүлэлд манай судлаачид “*хадны оршуулга*” хэмээсээр ирсэн дурсгалын талаар авч үзлээ. Хадны оршуулгыг байгалийн агуй хонгил, хөмөг, хадан нүхийг ашиглан үйлдэх тул гадна талаас нь хараад эртний оршуулга гэх шинж тэмдэггүй нууж далдалсан байдаг. Хад агуй хөмөгт шарилыг эсгий, торго даавуу, үйсээр ороож тавьсан тохиолдол байдаг ч ихэвчлэн толгой тал нь өргөн, хөл тал руугаа нарийсч намссан хэлбэртэй, углуургадаж үдсэн банзан авсанд малгай, гутал, хувцастай нь оршуулна. Талийгаачийг тэнэгэр байдлаар дээш харуулан толгойд эмээл болон зөөлөн эд (дээл) дэрлүүлэн хоёр гарыг их биеийн дагуу, хөлийг нугалж атийлгалгүй сунгаж тавина. Зүг чигийн тухайд ихэнх оршуулга уулын өвөр наран ээвэр талд ам үүд нь зүүн урагш болон урагш, баруун урагш харсан агуй хөмөг хонгилоос илэрч буй учир зүүн хойд, хойд, баруун хойд зүг чиглэжээ. Гэхдээ агуй хонгил хөмөг нь чулуун мандлын тогтоцоос шалтгаалж хэвтээ, хэвгий, босоо хэсгүүдийн хослолоос тогтдог тул шарилыг уулын орой оргил өөд хандуулсан байдаг.

Эд өлгийн зүйлсийг харилцан адилгүй дагалдуулна. Эрэгтэй хүнд голчлон зэр зэвсэг, малын тоног хэрэгсэл, аяга, сам, хавтагыг, эмэгтэйд богтаг малгай, хүрэл толь, сам, төмөр хутга, гоёл чимэглэлийн зүйлс, үндсэн аяга, бөс даавуу зэргийг хүүрийн зүүн баруун талаар тавьж сав суулгыг цээжин дээр хөмөрнө. Эдгээр агуй хөмөг хонгилын ам үүд нүх сүвийг чулуу өрж зориуд тагласан байх тул цаг уурын огцом халалт хөрөлт, ус чийгнээс ангид байж нэгэн хэвийн сэрүүн хуурай орчинд эд юмс нь маш сайн хадгалагдана. Иймээс хадны оршуулгаас хатмал шарил, хувцас өмсгөл, бусад эд өлгийн зүйл эвдрэл өгөршилд өртөлгүй гарах нь олонтаа байдаг.

Хадны оршуулгын хамаарах он цаг нь радиокарбоны шинжилгээгээр (10 оршуулга хамрагдсанаас эртнийх нь Баян-Өлгий аймаг Алтанцөгц сумын Хуурай Уулын оршуулга МЭ 370 оны үед, хамгийн хожуу үеийнх нь Хэнтий аймаг Дэлгэрхаан сумын Хүйтэн хошууных 1630-оны үед) IY зууны сүүл үеэс ХҮII зууны эхэн үед хамаарч буй бол типологийн аргаар харьцуулан үзэхэд ихэнх нь түрэгээс-монголын үеийнх болох нь баттай нотлогддог.

Сүүлийн үед манай орны хад асга ихтэй уулархаг хэсгээс хадны оршуулгын хэд хэдэн шинэ дурсгал илрэн олдлоо. Ийнхүү судалгааны хүрээнд баримт материал хуримтлагдахын хирээр зарим асуудлыг тодруулан авч үзэх үндсэн сурвалж болж байна.

Нууц далд оршоосон нь. Эндээс бидний өгүүлэх гол асуудал бол хадны оршуулгыг нууцалж далдалсан явдал. Яагаад агуй хаданд тусгайлан оршоох болов? Яагаад нууцлах болов? гэдэг асуудал анхаарал татна. Үүнтэй холбогдуулан сурвалж бичиг болон судалгааны зарим зохиол бүтээлээс үзэхэд ерөнхийдөө “хаад ноёд, язгуур сурвалжит хүнийг нууц далд оршуулдаг” гэснээс өөр тодорхой мэдээлэл үгүй байна. Эл асуудлыг тодруулахад археологийн хэрэглэгдэхүүнийг үндсэн баримт болгох учиртай.

Хадны оршуулгыг далдалж нууцгайлсан байдал юуны түрүүн тэдгээрийг анх олж мэдсэн байдлаас тодорхой харагдана. Ийм хэлбэрийн оршуулгыг нутгийн иргэд хонь хариулах, ан хийх, түлш түүж явахдаа огт санамсаргүйгээр тохиолдлоор олсон байдаг. Жишээлбэл: Ховд аймгийн Булган сумын харьяат П.Сундуйжав ууланд ан хийх явцдаа хадан хясааны өвөрт нэг янгир байхыг олж харан авлах санаатай хэвтэрт нь хүрэхэд дэвсгийн арын хад, чулуун хашааны хана шиг харагджээ. Ингээд сайн ажиглаж хартал нарийн хавтгай чулууг дээр дээрээс нь давхарлан өрлөг маягтай тавьсан байжээ. Ямар ч нүх, ам үгүй байсныг цохиж үзтэл хөндий дуу гарч нурааж үзэхэд агуйд тавьсан эртний оршуулга байжээ (Төрбат нар 2008). Мөн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Бичигт багт хэрэгжиж буй “Аргаль судлал” төслийн ажилтан Б.Отгонбаяр Нартын хад хэмээх газарт 2005 оны хавар аргалийн хурга барихаар явж байхад нь нэгэн багавтар агуйгаас аргаль гарч зугтжээ. Агуйд хурга байснаас гадна модон авсыг ширээр бүрсэн эртний оршуулга байгааг лавтайяа мэдэн цааш хөндөлгүй орон нутгийнхаа удирдлагад мэдээлжээ. Улмаар ШУА-ийн Археологийн Хүрээлэнгийн судлаачид мэдээллийн дагуу газар дээр нь очиход агуйн амыг хааж тагласан чулуунуудыг нурааж, модон эдийн жижиг хугархайг доош тараан хаясан байв” (Хүрэлсүх нар 2008).

Мэдээллийн дагуу мэргэжлийн судлаачид газар дээр нь очиж шалгаж баримтжуулалт хийх явцдаа далдалж нууцалсан байдлыг анхандаа төдий л анзаарч тэмдэглэж байсангүй. Гэвч сүүлийн үеийн судалгаагаар нууц оршуулга гэдгийг бататгах хэд хэдэн шинж тэмдэг байгаа харагдаж байна. Үүнд хадны оршуулга илэрсэн газар нь:

- а. Хүний хөл багатай
- б. Уул хадны бартаа нугачаа ихтэй
- в. Нарийн ам бүхий хадан нүх, хонгил, хөмөг, багавтар агуй зэрэг аль болох нууж далдлах боломжтой газарт
- г. Агуйн ам, үүдийг чулуугаар өрж далдлах
- д. Байгалийн бэлэн халхавч бүхий газар

болно. Энэ нь тэр бүр нүдэнд тусах агуй хонгилд бус харин нууцлагдмал газар байх бөгөөд гярхайлан анзаарвал тухайн газар орчны байдлаас мэдэгдэнэ. Энэ талаар “хүн анзаарч ажиглахааргүй хадны завсарт тавьж хавтгай чулуунуудаар хучин далдалдаг” хэмээн археологич Д.Эрдэнэбаатар тэмдэглэсэн бөгөөд цааш дэлгэрүүлэн авч үзээгүй байна (Эрдэнэбаатар 1996).

Сурвалж. Хадны оршуулгын тухай монголын түүхийн тулгар сурвалжууд хийгээд эртний их элчисийн тэмдэглэлд хэсэг бусаг мэдээ багагүй тохиолдож байна. Үүнээс заримыг нь дурдвал: Дундад зууны монголын түүх, аж ахуй, нийгэм соёлын тухай тэмдэглэсэн монгол үндэсний их сурвалж болох Монголын Нууц Товчоонд энэхүү төрлийн оршуулгыг тэмдэглэхдээ, §175-д “Хуйлдар шархаа анаагүй байхад Чингис хаан ятгасаар байтал үл болон гөрөөсөнд довтолж, үгдэрч нөгчив. Тэнд Чингис хаан Халхын Ор нугын Хэлтгий хаданд ясыг нь тавиулав”

(Цэрэнсодном 2005) гэсэн бол Плано Карпинигийн тэмдэглэлд нууж тавьсан талаар “ихэс дээдсээс хэн нэгэн нас нөгчвөл тэд өөрсдөө газраа сонгож нууцаар нутаглуулна. Газрын дээд хэсгийг хөрстэй нь авч бэлтгээд талийгаачийг оршуулж нүхийг эргэн булаад тэр булшийг дахин хэн ч хэзээ ч олохооргүй болгохоор үндэстэй нь авсан хөрсийг дээрээс эгнүүлэн суулгана” гэжээ (Плано Карпини 2006).

А.Амар гуайн “Монголын товч түүх” зохиолд “эрт цагийн монголчууд өөрсдийн хаадын оршуулсан газрыг харь этгээдээс туйлын нуудаг” гээд “газрыг гүн ухаж, авсыг булсны хойно хэдэн мянган адуу бэлчээх буюу эсвээс илүү шороог бус газар аваачиж ухсан газрыг тэгш болгоно. Энэ нь ирэх хавар ногоо ургахад булш буй хэмээн огт мэдэгдэхгүй нууц булдаг бөгөөд бас анх булахад нэг ботгыг түүний эхийн нүдний өмнө алж, мөнхүү газар булдаг бөгөөд хойд жилийн ойд хүүрийг тахихад мөнөөх ингийг тавьдаг нь тэр буйлан гүйсээр ботгоо булсан газар очдог учир, үүгээр үхэгсдийн булш буй газрыг олдог ажгуу” хэмээсэн (Амар 1989).

Марко Пологын аяны тэмдэглэлд “Чингисийн удам угсааны их хаадыг цөм Алтайн их ууланд онголон оршуулна. Татарын их эзэн хаад хаана халин одсон ч, ер Алтайн улсаас зуун өдөрчийн хол газар байвч ялгаагүй, тэр ууланд аваачиж нутаглуулдагийг мэдвэл зохилтой. Өөр бас нэг гайхалтай зүйл буй. Үүнд: Их хаадын шарилыг онголохоор дөчин хоногийн турш залж явах замын гудаст тохиолдсон аливаа бүх хүнийг барагцаалбал, өдөрт дөч буюу заримдаа түүнээс олон, заримдаа түүнээс цөөн хүнийг цөм мэслэн хороогоод, <<манай эзэн хааныг дагалдан нөгөө ертөнцөд одож хүчээ өгөгтүн>> хэмээн хэлээд шарилыг дагуулан хойллого хийнэ. Тэд тэр хороогдсон хүмүүсийг нөгөө ертөнцөд одож эзэндээ үйлчилдэг хэмээн нутад итгэцгээдэг авай. Мөнх хаан таалал төгсөхөд түүний шарилыг онголохоор Алтайн уул руу залж явах замын зуурт тохиолдсон хоёр түм илүү хүнийг хороосныг мэдэлтэй” хэмээжээ (Марко Поло 1987).

Хятадын зарим сурвалж бичигт “тэд хүн оршуулахдаа булш босгодоггүй бөгөөд шарилыг газарт булсны дараа сүрэг адуу давхиулж газрыг нь тэгшилдэг болно. Тэмүжиний оршуулсан газрыг тойруулан хашиж морьт харуул тавьсан” (Баясах 2006) гэжээ.

Хятаны хаадыг оршуулах ёслолын тухай Хуо чао <<Мэхт барих тэмдэглэл>> хэмээхдээ “их уулсын өмнө хүрч, нар мандах үед оршуулж дагалдах эд өлгийг хийж үүдийг хаав, дараа өдөр нь үүдийг нээж, ёслол үйлдэв. Ёслолын талаар дэлгэрэнгүй лавлахад нууц гээд хариу эс өгөв” гэж өгүүлжээ (Хуо Чао 1999).

Мөн энэ талаар Өвөр Монголын судалгаанд “хүүр онгоныг хэзээ ч гэсэн хүмүүст үл мэдэгдэхийн тулд битүү далд байлгахыг нууцлан оршуулах гэнэ. Энгийн ярианд нууцлан оршуулах гэж хэлэхгүй, харин “нуумуй”, “далд оруулмуй” гэдэг. Нууцлан оршуулах ёс нь талийгаачийн хүүрийг газрын хөрсөнд гүн гэгч оршуулж, хүнд мэдэгдүүлэхгүйн төлөө ямарч овоо чулуу тэмдэг сэлт тавьдаггүйгээрээ гол онцлогтой. Энэ нь тухайн үеийн нүүдэллэн амьдарч байсан овог аймгууд байр суурь болон бэлчээр ба хүн ам, эд өлгийн булаалдаан өвөг

дээдсийн өшөө хонзон зэрэг шалтгаанаас болж үргэлж дайн дажин үүсгэж ялсан нь ялагдсаныхаа дээдсийн хүүр онгоныг уудалдаг байсан лугаа холбоотой” (Хурцбилэг 2003) гэсэн мэдээ байдаг.

Түрэг болон монголын их хаад, ноёд, ихэс язгууртны гэх хэв шинжийг хадгалсан булш оршуулгыг илрүүлэн олж малтаж судалсан явдал одоо хүртэл хийгдээгүй нь ихэс дээдсийн яс хөндөгдөж тоногдохоос ихэд болгоомжилж чанд нууц оршуулдаг заншил, тэдний гэгээн хүүрийг оршоодог <<Ихсийн газар>>, <<Их хориг>> хэмээх оршуулгын газрууд гаднах хэлбэр төрх зохион байгуулалт гэхээр ямар нэг шинж тэмдэггүй нууцлагдмал байдагтай холбоотой байна. Тэгээд ч “жилийн дөрвөн улиралд бэлчээр усаа даган нүүдлийн байдлаар аж төрдөг цөөн хүн амтай, уудам дэлгэр нутагтай монголчуудын хувьд хаад ихэсийн булшийг үргэлжийн харуул манаатай, олны нүдэнд ил тод байлгах боломж хомс, хэн хүн дуртай цагтаа ухаж малтаж болох онцлогтой байжээ. Үүнээс сэргийлэх хамгийн сайн арга нь шарилыг бусдын нүднээс нууцлан онголж, түүгээр ч барахгүй, хүмүүсийн бодол санааг төөрөлдүүлэх зорилгоор олон төрлийн яриа зохиож нийтэд тархаан итгүүлэх явдал байсан” (Баяр 2000) бөгөөд ихэсийн далд нууц оршуулга нь дараа дараагийн үедээ мартагдан домгийн чанартай хууч яриа болон иржээ.

Нууц оршоох болсон шалтаг шалтгаан. Эртний нүүдэлчин овог аймгууд ихэнхдээ хөрш зэргэлдээ овог аймгаа түрэмгийлэн довтолсны дараа эртний ёсоор өшөө хорслоо тайлж доромжлон гутаах, эд агуурсыг нь олзлох зорилгоор ихэс дээдсийнх нь хүүр онгоныг тонон дээрэмдэж байсныг заримдаа нүдээр үзэж чихээр сонсч байсан тул хүүр онгоноо нууцлахын чухал чанарыг сайн ойлгосон байжээ.

Энэ нь хүүр онгонд дагалдуулсан эд өлгийг хамгаалах ба үхэж хэвтэх ясаа үл хангинуулах зорилготой байдаг болохоор голдуу овог аймгийн эзэд, язгуур угсаа гарал бүхий эрх мэдэлтнүүдийг оршуулахад голчлон тохиолдоно. Энэ талаар В.С.Таскин “Жао-ди хааны үед (НТӨ 86-73 он) Уханьчууд аажмаар хүчирхэгжих үедээ, Хүннүгийн шаньюйн шарилуудыг ухаж Маодунд өширхсөн өшөө хорслоо авчээ. Үүнд ихэд хилэгнэсэн хүннүчүүд зүүн зүгт довтолж Уханьчуудтай тулалдан тэднийг бут цохисон” хэмээн (Таскин 1984) хятад эхээс нь иш татсан бол Х.Пэрлээ гуай “ХП зууны сүүлчээр Хэрэйдийн Ван ханы нутагт <<хориг>> гэдэг хүүр оршуулах газар байсны нь Найманы цэргүүд дээрэмдсэн тухай” мэдээг (Пэрлээ 1956) тэмдэглэжээ.

Дээр өгүүлсэнтэй адил ихэс дээдсийн хүүр онгоныг тонон дээрэмдэж, түүхэн өв дурсгалыг нь эвдэн түйвээх үзэгдэл хүннүгийн сүүл үеэс эхэлж улмаар дундад эрт үед түгээмэл байсан ч хамгийн олиггүй ёрын үйлд тооцогдох учир энэ талын мэдээ баримтыг тэр бүр тэмдэглэж бичиглэж үлдээсэнгүй. Тухайлбал, түрэг болон монголын үеийн хүн чулуун хөшөөдийн ихэнхийнх нь толгойг тасдаж зарим нэгийг нь хугалж гэмтээсэн байдаг (Зураг 1) (Баяр, Эрдэнэбаатар 1999).

Он цаг болон харилцан хамаарал. Нууцгай оршуулга гэж үзэхэд холбогдох он цаг ихээхэн анхаарал татна. Хадны оршуулгуудын дийлэнх нь түрэгээс-монголын үе буюу VII-XIV зуунд холбогдож буйг лабораторийн нарийн шинжилгээнээс гадна илрэн олдож байгаа түрэг-монголын үеийн дурсгалын гол элементүүд болох монгол эхнэрийн богтого малгай, нүүдэлчдийн хэрэглэдэг зөв болон буруу энгэртэй хувцас өмсгөл, уужим суудал бүхий эмээл, босоо дөрвөлжин сэнжтэй төмөр дөрөө, эсгий оймс бүхий арьсан бойтог, ухмал модон аяга, зэр зэвсгийн зүйлс зэрэг эд хэрэглэгдэхүүнүүдийг харьцуулан жиших замаар төвөггүй мэдэж болно.

Эрт цагийн нүүдэлчид ихэс дээдсээ оршуулахдаа чулуу мод ашиглан ёслол төгөлдөр байгууламж үйлддэг байжээ. Тухайлбал, Хүннүгийн язгууртны сүр бараатай үйлдсэн оршуулга манай улсын Ноён Уул, Гол Мод, Гол Мод II, Дуурлиг Нарс, Тахилтын Хотгор, Бор Булаг, Буриадын Иволгын Ам (Зураг 2) зэрэг газарт буйг археологичид малтан судалж байна. Харин Түрэгийн үеэс язгууртны тахилгын байгууламжийг сүр бараатай үйлдэж харин үнэн хүүрийг хаа нэгтэй нууц далд тавьжээ. Үүнд бид Хөшөө Цайдам, Тоньюкук, Онгийн дурсгалуудыг дурдаж болно.

Нууцлан оршуулах үйл явц цааш Монголын эзэнт гүрний үед улам нарийн чанд болж, хүчирхэг нэр цуутай байх тусам нүдэнд илэрхий тусах (нууц тэмдэглэгээ байхыг үгүйсгэхгүй) ямар нэгэн байгууламж огт үйлддэггүй байдлаар хэлбэршин тогтсон хэмээн үзэж болно. Эл байдалтай уялдан ихэс дээдсийн хүүр онгоныг ямар нэгэн байдлаар ухаж тоносон тохиолдолд шийтгэн цээрлүүлэх тухайн үеийн хууль цаазын чанга хатуу заалттай байснаас нууцгайлахын учир зүйг мэдэж болно. Тухайлбал, Чин улсын үед, монголчуудын зан заншлын хууль болон өөрийн (Чин улсын) хууль дүрмийг харгалзан Гадаад Монголын төрийг засах явдлын яамнаас гаргасан “Хууль зүйлийн бичиг”-ийн 1178-р зүйлд “эртний хатдын хүүрийг ухаж тонох болбоос, авсыг нь үзээгүй бол тэргүүлсэн хүмүүсийг хөвчдөн алах ял торгож, гянданд хориод хүлье. Дэд болж явсан хүнийг цөлж, өртөөд тушаан өгч зовох албанд явуул. Авс үзвээс тэргүүлсэн хүнийг хөвчдөн алах ял торгож даруй ал. Дэд болж явсан хүнийг хөвчдөн алах ял торгож гянданд хориод хүлье. Авс нээж яс үзвээс тэргүүлсэн хүнийг цавчин алах ял торгож даруй ал. Дэд болж явсан хүнийг хөвчдөн алах ял торгож гянданд хориод хүлье. Ясыг эвдэж гээхүй болвоос, тэргүүн дэд үл ялган цөм цавчин алах ял торгож алагтун” гэжээ (Хурцбилэг 2003).

Эдгээр археологийн болон сурвалж бичгийн мэдээ нь ямартай ч нууц далд оршуулга байсныг баттай илэрхийлж байна.

ДУГНЭЛТ

Эндээс хадны оршуулгыг өвөрмөц гэхээс илүү нууц далд оршуулгын нэгэн хэлбэр (хувилбар) хэмээн үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл тухайн нийгмийн ноёлох хэсгийн төлөөлөл бүхий талийгаачийг далд нууц оршоож хөрс зүйх, мөр дайруулах, ингэ буйлуулах, гэрчийн хэл таслах, хориг тогтоох, манаа гаргах, мод

тарих, үл тэмдэглэх, мөрөө баллаж төөрөгдүүлэх зэрэг хэлбэр байснаас гадна агуй хаданд нууж далд оршоох заншил байжээ.

Хадны оршуулгуудын ихэнхийг их бага хэмжээгээр тонож сүйтгэсэн хэдий ч харьцангуй бага сүйдсэн Алхамын хавцалын оршуулгын торго, мөнгөн ээмэг, Цагаан Ханангийн оршуулгаас гарсан язгуур сурвалжит хүний малгай, гутал, хувцас өмсгөл (Зураг 3), Нартын Хадны оршуулгын эмэгтэйн хувцас, чимэглэлийн байдал (Зураг 4, 5) нь Юан гүрний үеийн зургадугаар дэсээс доошгүй язгуур сурвалжтай хүний эд хэрэглэлтэй (Зураг 6) үндсэндээ тохирч байдаг бол Дугуй Цахирын оршуулга язгуур угсаатай баян чинээлэг хүний (Зураг 7, 8), Арцат Дэл (Зураг 9, 10), Жаргалант Хайрхан, Ёдортын оршуулга жирийн иргэдийнх бус болохыг оршуулгын эд хэрэглэгдэхүүн нотлон харуулдаг.

Тиймээс бид биет хэрэглэгдэхүүнд дулдуйдан хадны оршуулга нь жирийн иргэдийнх байхаас илүүтэй язгууртан буюу тухайн нийгмийн ноёлох чинээлэг хэсгийнхний оршуулга байх бүрэн боломжтой хэмээн урьдчилсан байдлаар үзэж байна.

Хадны оршуулгыг нэлэнхүйд нь язгууртны гэж үзэх нь мэдээж учир дутагдалтай. Язгууртан гэхээр хаад ноёдын хэмээн шууд ойлгож болохгүй бөгөөд тухайн нийгмийн эрх мэдэл бүхий баян чинээлэг хэсгийнхний гэдгийг давтан тодотгож байна.

Оршуулгын ийм хэлбэр байнгын тэмцэлтэй самуун цаг хийгээд нүүдлийн ахуй байдлаас илүүтэйгээр өмнө дурдсанчлан өшөө хорслоо тайлж доромжлон гутаах зорилгоор ихэс дээдсийнх нь хүүр онгоныг ухаж эд агуурсыг нь олзлох болсонтой шууд хамааралтай бөгөөд хүннүгийн дараах төрт улсын үеэс эрх мэдэл бүхий баян чинээлэг хэсгийнхнийг нууцгай тавих нөхцөл бүрдэж хойд үедээ уламжлан тогтжээ. Энэ нь дараа дараагийн судалгааны хэрэглэгдэхүүнээр улам баяжиж оршуулгын зан үйл хийгээд голчлон язгуур сурвалжит хүний оршуулга мөн эсэх талаар ч асуудал хөндөгдөх нь зайлшгүй.

Эцэст нь агуй, хонгил, хөмөг дэх оршуулга нь байгалийн бэлэн байр савыг ашиглан аль болох нууцгай далд хийгдсэн байх тул бусад дурсгалын адил нүдэнд ил тусах хэлбэр зохион байгуулалтгүй, мөн тэдийг малтан судлана хэмээн төлөвлөх боломжгүй бөгөөд хамгийн чухал нь хөндөөгүй бүрнээр нь баримтжуулан авч цогц байдлаар судалгаа хийхэд бэрхшээл учирч байдгийг тэмдэглэж байна.

НОМ ЗҮЙ

Амар, А. 1989. Монголын товч түүх. Улаанбаатар.

Баяр Д., 2000. Алтан ургийн язгууртны нэгэн булшийг судалсан нь. Улаанбаатар

Баяр, Д. Эрдэнэбаатар, Д. 1999. Монгол алтайн хүн чулуун хөшөө. Улаанбаатар.

Баясах, Ж. 2006. Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг. Улаанбаатар.

- Марко Поло*. 1987. Орчлонгийн элдэв сонин. Редактор С.Бадамхатан. Улаанбаатар.
- Плано Карпини*. 2006. Монголчуудын түүх. Улаанбаатар. /итали хэлнээс орчуулсан Л.Нямаа/
- Перлээ, Х.* 1956. Эртний Монголчуудын үхэгсдээ оршуулж байсан зан үйлийн асуудалд. Улаанбаатар.
- Таскин, В.С.* 1984. Материалы по истории древних кочевых народов группы дунху. Москва.
- Төрбат, Ц. Батсүх, Д. Батбаяр, Т. Баярхүү, Н. Идэрхангай, Т.* 2008. Монгол Алтайгаас илэрсэн хадны оршуулгууд. *Studia Archaeologica. Tomus. (VI) XXVI fasc. 14*, Улаанбаатар.
- Цэрэнсодном, Д.* 2005. Монголын Нууц Товчоо. Улаанбаатар.
- Хурицбилэг, Н.* 2003. Монголчуудын оршуулгын соёл. /хуучин монгол бичгээр/ Хөх хот.
- Хуо Чао*. 1999. Ляо улсын түүх. (Liao shi) Бээжин.
- Хүрэлсүх, С.* 2008. Монгол нутаг дахь агуйн эртний оршуулгын судалгааны байдал. *Studia Archaeologica. Tomus. (VI) XXVI fasc. 15*, Улаанбаатар.
- Эрдэнэбаатар, Д.* 1996. Монгол Алтайн хадны оршуулга. *Studia Archaeologica. Tomus. XVI fasc. 9*, УБ.

SUMMARY

S. Khurelsukh

ANCIENT CAVE BURIALS IN MONGOLIA

Findings from cave burials in Mongolia provide much of information on the funerary custom of ancient nomads. In this paper the author discusses about hidden burials based on archaeological findings and historical source materials.

From historical sources we know that ancient nomads had different ways to hide their burials, especially of those who are of higher social rank, such as hanging the soil, wiping the tracks out, weeping the female camel, cutting witnesses' tongue, setting obstacles, guarding the region, planting trees and composing different legends. In addition to these, based on the findings from Alkhamiin Khavtsal, Tsagaan Khanan, Nartiin Khad, Dugui Tsakhir and Artsat Del, the author considers the cave burial as one of the types of the hidden graves representing the ones of the upper social status.



Зураг 1. Түрэгийн үеийн язгууртны тахилын онгон, хүн чулуун хөшөө



Зураг 2. Хүннүгийн язгууртны булш



Зураг 3. Цагаан Ханангаас гарсан малгай, зүүсгэл, торгоны тасархай, . ширэн гутал

ХАДНЫ ОРШУУЛГА ХИЙГЭЭД ЭРТНИЙ НҮҮДЭЛЧИД ИХЭС ДЭЭДСЭЭ НУУЦ ДАЛДАД ОРШООДОГ
ТУХАЙ



Зураг 4. Нартын Хадны оршуулга.



А.



Б.



В.



Г.



Д.

Зураг 5. Нартын Хад. А. Магнаг торгон дээл, Б. Дээлийн зах, эмжээр, В. Арьсан дээлийн хээ чимэг, Г. Луун хээтэй магнаг торго, Д. Арьсан гутал



А.



Б.



В.

Зураг 6. А. Өлзийт Төмөр хаан (1265-1307), Б. Уйгур гүнж. Ханын зураг IX зуун. В. Чаби хатан. XIII зуун.

ХАДНЫ ОРШУУЛГА ХИЙГЭЭД ЭРТНИЙ НҮҮДЭЛЧИД ИХЭС ДЭЭДСЭЭ НУУЦ ДАЛДАД ОРШООДОГ
ТУХАЙ



Зураг 7. Дугуй Цахир. Эсгий хэвнэг (дээл?), торгон эмжээртэй арьсан дээлийн энгэр, арьсан гутал



А.



Б.

Зураг 8. А. Дугуй Цахирын оршуулгын эд зүйлсэд тулгуурлан сэргээн төсөөлсөн нь (Зураач О.Ангарагсүрэнгийнхээр).
Б. Культегин жанжин VII-VIII зуун. Сэргээсэн нь (М.В.Гореликийнхээр)



Зураг 9. Арцат Дэлийн оршуулга



Зураг 10. Арцат Дэл. Нум сум, хоромсого, ташуур, төмөр дөрөө, амгай зуузай, модон хуйтай төмөр сэлэм